

БНХАУ-ЫН ШИНЭТГЭЛ, НЭЭЛТТЭЙ БОДЛОГЫН ГҮНЗГИЙРЭЛТ БА МОНГОЛ-ХЯТАДЫН СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦАА

Д.Шүрхүү*

Эрхэм хурлын дарга аа,

БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ, манай Олон улс судлалын хүрээлэн хамтран зохион байгуулж буй эрдэм шинжилгээний хуралд морилон ирсэн эрхэм хүндэт зочид, ноёд хатагтай та бүхний энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилье.

Миний өмнө БНХАУ-аас тус хурлын гол илтгэлийг тавихаар уригдан ирсэн нэртэй улс төрч, судлаач ноён Жао Цижэн 2020 он хүртэлх Хятадын шинэтгэл, нээлттэй бодлогын чиг хандлага, үндэслэл, гол зорилтуудын талаар маш тодорхой ярьсан тул би энэ тухай давтан ярихгүй. Зөвхөн Хятадын шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлт нь Монгол-Хятадын харилцаанд хэрхэн нөлөөлөх вэ, ямар шинэ боломж олгох вэ гэдэг талаар судлаачийн байр суурийг илэрхийлмээр байна.

Юуны өмнө бид өмнөд хөршөө, түүний дотор шинэ удирдлагын зүгээс дотоод, гадаад бодлогын талаар дэвшүүлж буй зорилго, зорилтуудыг ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл өргөн хүрээнд хамтран ажиллах гэж буй, худалдаа наймаа хийх гэж буй түншээ таньж мэдэхгүйгээр харилцан ашигтай хамтран ажиллахад хэцүү. Ялангуяа Си Зиньпин тэргүүтэй Хятадын 5 дахь үеийн удирдагчид сүүлийн саруудад 2020 он хүртэлх бодлого, стратегиа тодорхойлж, замын зургаа зарлан тунхаглалаа. ХКН-ын ТХ-ны 18 дахь удаагийн 3-р бүтг хурлаас нийгмийн бүхий л салбарыг хамарсан чухал тогтоол гарлаа. Энэ бол БНХАУ-ын дотоод, гадаад нөхцөл байдал амаргүй байгаа боловч Хятадын шинэ удирдлага шинэтгэл, нээлттэй бодлогоо тууштай үргэлжлүүлэн гүнзгийрүүлэх замаар улс орныхоо тогтвортой хөгжлийг хангах байр суурийн илэрхийлэл юм.

*Д.Шүрхүү-ШУА-ийн ОУСХ-ийн захирал доктор, дэд профессор

БНХАУ-ын шинэтгэл, нээлттэй бодлого гүнзгийрэх шатандаа орж байгаа нь Монгол улсын маш ойрын гадаад орчинд болж буй чухал үйл явдал бөгөөд хөрш Хятад улсын тогтвортой хөгжил цэцэглэл нь манай улсын хөгжилд, тухайлбал эдийн засагт нь шууд нөлөөлөх хүчин зүйл юм.

Дээрхи өөрчлөлт шинэтгэлийг ХКН-ын ТХ-ны 3-р бүгд хурлын шийдвэрт түүхэн шинэ эхлэл хэмээн тодорхойлсон нь Хятадын энэ удаагийн өөрчлөлтийн бодлогын цар хүрээ, Хятадын хөгжилд ямар их ач холбогдолтойг харуулж буй юм.¹

Нөгөөтэйгүүр энэ нь маш хүнд эрсдэлтэй үйл явц гэдгийг тус хурлын шийдвэрт "бэрхшээлийг даван туулах цаг үе тулгараад байна" гэж ² цохон тэмдэглэснээс харж болох.

Хоёрдугаарт, Хятадын энэ удаагийн өөрчлөлт шинэтгэлийн бодлогын онцлог бол эдийн засгийн хөгжлийн загварыг нэлээд ул суурьтай өөрчилж байгаад орших бөгөөд ач холбогдол, далайцаараа дэлхийн эдийн засагт ч шууд нөлөөлөх юм.

Монгол улс нь Хятадын шинэтгэл, нээлттэй бодлогын хэрэгжилтээс эдийн засгаа хөгжүүлэх түлхэц олж авахаас гадна мөн хөгжлийн туршлагаас нь санаа авах боломжтой.

Хятад улсын гадаад бодлого, хөрш орнуудтайгаа харилцах харилцааны үзэл баримтлал нь 2013 оны 11-р сарын 9-12 нд хил орчим, хөрш зэргэлдээ орнуудын талаар баримтлах бодлогын тухай хаалттай хэлэлцсэн зөвлөгөөнөөс гарсан шийдвэр гэж ойлгогдож байна. Тус зөвлөгөөн дээр Хятадын дарга Си Зиньпиний хэлсэн үгийн товчлол болон Хятадын төвийн хэвлэлд гарсан тайлбар өгүүлүүдээс харахад хөрш орнуудтайгаа харилцах харилцааны үзэл баримтлал нь Хятад улсын гадаад бодлогын амин сүнс биш юмаа гэхэд маш чухал бүрэлдэхүүн хэсэг юм гэдэг нь тодорхой байна. Энэхүү бодлогын зорилго бол Хятадын дарга Си Зиньпиний хэлсэнчлэн Хятадын ард түмний "хоёр зуун жилийн турш сэргэн мандах мөрөөдлөө гүйцэлдүүлэхийн төлөө хийсэн тэмцлийг бодитойгоор хэрэгжүүлэхэд орших ажээ. Иймийн тулд хөрш орнуудтай найрсаг харилцаагаа бүхий л талаар хөгжүүлэн бэхжүүлж, харилцан ашигтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн, Хятад улсын хөгжлийн стратегийн энэ цаг үеийн чухал боломжийг ашиглан Хятад улсын тусгаар,

аюулгүй байдал, хөгжлийн эрх ашгийг сахин хамгаалах замаар хөрш орнуудыг Хятад улстай улс төрийн харилцаагаа илүү найрсаг болгох, эдийн засгийн хэлхээ холбоогоо улам бэхжүүлэх, аюулгүй хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн, ард иргэд, соёлын харилцааг улам нягтруулахад хүчин чармайлт гаргах³ шаардлагатай гэжээ.

Дээрхи зөвлөгөөний үзэл баримтлал ч манай оронтой цаашид харилцах харилцааны чиг баримжааны үндэс суурь болох юм.

Ийнхүү БНХАУ-д шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлтийн үйл явц эхэлснээр манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд шинэ үе шат нээгдэж байна.

Монгол Улсын засгийн газрын тэргүүн Н.Алтанхуяг БНХАУ-д албан ёсны айлчлал өнгөрсөн сард хийж хоёр орны хооронд "стратегийн түншлэлийн дунд,урт хугацааны төлөвлөгөөнд" гарын үсэг зурсан нь хоёр орны харилцааны хөгжлийн шинэ үе шат, шинэ боломжийн эхлэл тавигдав.

Хятадын дарга Си Зиньпин ерөнхий сайд Н. Алтанхуягтай уулзах үеэр хэлсэн үгэндээ манай улстай хөгжүүлэх хамтын ажиллагааны зорилт, хоёр талын харилцаанд байгаа зарим нэгэн шийдвэрлэх зохистой асуудлуудыг хөндсөн билээ. Хятад улсын шинэ дарга хоёр орны харилцааг хөгжүүлэх механизмыг идэвхжүүлэх асуудлыг хөндөн хоёр орны стратегийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, чингэхийн тулд хоёр талын стратегийн шинж чанартай асуудлаар олонтоо хэлэлцэн ярилцаж, хоёр орны парламент, засгийн газар, намын түвшинд идэвхтэй харилцах шаардлагатайг тэмдэглээд хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны хөгжлийн үндэс суурь бол "Хятад Монголын стратегийн түншлэлийн харилцааны дунд, урт хугацааны хөтөлбөр" болохыг цохон дурдав. Улмаар практик үйл ажиллагааны түвшинг дээшлүүлэх, нөгөөтэйгүүр Хятадын зах зээл, хөрөнгө мөнгө, хүний хүч, техник, зам харилцааг Монголын талд аль болохоор нээлттэй байлгаж хоёр тал бие биеэ нөхөх давуу талаа ашиглах, байгалийн баялгийн ордыг нээх, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон банк санхүүгийн гурван салбарын хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд "гурвыг нэгтгэн нэгдсэн төлөвлөгөөтэй урагшлах" гэсэн хамтын ажиллагааны

ерөнхий үзэл санааг дэвшүүлсэн юм. Уул урхайн салбар дахь маш том төслийг хамтын ажиллагааны гол үндэс болгож төслийн хэрэгжилтийг дагалдуулан Хятад-Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааг хэмжээ, чанарын хувьд шинэ шатанд гаргах⁴ тухай ярьсан билээ.

Мөн Хятадын ерөнхий сайд Ли Кэцян манай ерөнхий сайд Алтанхуягтай уулзах үедээ Хятадын засгийн газар монголын талтай нэг замаар урагшилж даян дэлхийн глобалчлалын хандлагын дагуу хоёр орны стратегийн түншлэлийн харилцааг цаашид хөгжүүлэх эрмэлзэлтэй байна гээд таван зүйлийг онцолсон бөгөөд үүнд: нэгт, улс төрийн итгэлцлийг нэмэгдүүлж стратегийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэх. Хоёр тал бие биенийхээ амин чухал эрх ашиг болон чухал зангилаа асуудал дээр харилцан бие биенээ цаашид ч үргэлжлэн тууштай дэмжих. Хоёрт, хүчин чармайлт гарган харилцан холбогдол бүхий дэд бүтцийн үндэс суурийг бүтээн байгуулах, тухайлбал төмөр зам, авто зам, цахилгаан эрчим хүч зэрэг салбарт нэгдмэл төлөвлөгөөтэй, нэгдмэл бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх. Гуравт, том төслийг хамтын ажиллагааны амин сүнс болгон түүнийг дагалдуулан эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг бүхий л талаар хөгжүүлэх. Хятадын тал монголын талын аж үйлдвэрийн парк болон эдийн засгийн парк байгуулах явдлыг дэмжиж байгаа ба монголын талтай хамтран хил орчмын бие даасан худалдааны бүс байгуулах зорилгоор судалгаа хийх сонирхолтой байгаа. Дөрөвт, валют санхүүгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын нөхцлийг сайжруулах Талууд тус бүр өөрийн орондоо хамтрагч талынхаа үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтын таатай нөхцлийг бүрдүүлж өгөх. Тавд, боловсрол, соёл урлаг, залуучууд, орон нутгийн зэрэг солилцоо, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх гэжээ.

Хятадын тал Монгол улстай стратегийн түншлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд юуны түрүүнд хоёр улсын харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн үзэж Хятад улсын хоёр дарга тус бүрнээ энэ тухай онцлон тэмдэглэсэн билээ. Тухайлбал Хятадын дарга Си Зиньпин Хятад-Монголын стратегийн түншлэлийн харилцааг хоёр ард түмний чин эрмэлзэл дээр суурилуулах чухлыг онцолсон байна⁵.

Стратегийн түншлэлийн харилцаа хэрэгжих шатандаа орж байгаагаар хоёр орны эдийн засгийн харилцааны бүтцэд том өөрчлөлт бий болж байгаа юм. Үүнийг Ерөнхий сайд Н.Алтанхуяг, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кэцян нарын хэлэлцээ болон Засгийн газрын тэргүүнүүдийн баталсан «Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр"- ийн дагуу үйлдсэн санамж бичиг, 20 гаруй хамтын ажиллагааны гэрээнээс харж болох юм. Тухайлбал нүүрс хийжүүлэх үйлдвэр байгуулах, хийн түлш үйлдвэрлэн экспортлох, Монголд нийлүүлэх газрын тосны бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, Монголын хүрэн нүүрсний ордыг түшиглэн шатах хийн үйлдвэр байгуулж, уг үйлдвэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах, Монголд олборлож буй түүхий тосны хэмжээ цаашид жил бүр өсөхтэй уялдуулан Хятадаас нийлүүлэх шатахууны хэмжээг нэмэхээр УУЯ-ны Газрын тосны газар, Хятадын "Петрочайна интернэйшнл" компанийн хооронд санамж бичиг байгуулсан, Монгол Улс өөрийн олборлосон түүхий тосоо МГЛ-93 автобензин болгоод, сард 10 мянган тонн хүртэл хэмжээгээр урд хөршөөс татан авахаар тохирсон, Замын-Үүд өртөөн дэх шингэн түлш шилжүүлэн ачих төхөөрөмжийн өргөтгөл хийгдсэнээр сард 35-40 мянган тонн шингэн түлш шилжүүлэн ачих боломжийг бүрдүүлэх. Мөн БНХАУ-ын төрийн өмчит "Шэньхуа групп"-ээр ахлуулсан концерциум Монгол Улсын хилийн Гашуун сухайт боомтын өртөөг Хятадын Ганц модны хилийн боомттой холбосон ачаа тээврийн боомтын төмөр зам барьж "Монголын төмөр зам" ТӨХК-д хүлээлгэн өгөхөөр санамж бичиг үйлдсэнээс харж болох юм. Ийнхүү хоёр орны эдийн засгийн харилцаанд худалдааны харилцаа давамгайлж байсан бол шинэ нөхцөл байдалд бүтээн босголтын хамтын ажиллагаа эрс нэмэгдсэнээр харилцааны бүтцэд чухал өөрчлөлт орох юм.

Хятадын шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлтийн гол зорилго бол зах зээл рүү улам эрчимтэй ороход чиглэгдэж байгаа болно. Үүнтэй холбогдуулан ХКН-ын ТХ-ны 3-р бүгд хурлаас гарсан шийдвэрийн "Нээлттэй эдийн засгийн шинэ механизмыг байгуулах "хэсэгт дотоод гадаад зах зээлийг сайтар уялдуулах, эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох

мөн түүнийг тэргүүлэх, үүний тулд дотоод гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг нэгтгэн нэг болгож гадаад хөрөнгө оруулалтын бодлогыг тогтвортой, ил тод болгох тухай заалт орсон нь мөн манай хоёр орны харилцаанд ч шууд хамааралтай зүйл хэмээн бодогдоно. Тус баримтанд мөн гадаадад хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж болон хувь хүний статусыг өндөржүүлэх, компаниудыг нэгтгэн нийлүүлэх замаар аж ахуйн нэгж байгуулах, үнэт цаас худалдан авах замаар болон бусад хөрөнгө оруулагчидтай хамтран хөрөнгө оруулахыг зөвшөөрнө гэж заажээ⁶. Үүнээс гадна гадаад дахь хөрөнгө оруулалтын хяналтын системийг өөрчлөх, консулын зүгээс хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэргээр эрх ашгийг нь хамгаалах замаар хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны системийг боловсронгуй болгох⁷ тухай өгүүлжээ.

Эх газрын хилийн бүст нээлттэй бодлогыг өргөжүүлэх, тээврийн салбарт зах хязгаарын нутгуудын хооронд хамтын ажиллагааг өргөжүүлэхээс гадна хил орчмын нутгуудыг хөрш орнуудтай нь холбох эдийн засаг-зам тээврийн сүлжээг бий болгох тухай дурджээ. Энэ нь дотоод гадаад дахь шинэтгэл, нээлттэй бодлогын уялдаа холбооны нэг тод жишээ юм. Ер нь судлаач хүний нүдээр харахад Хятад улсын зах хязгаар, хил орчим нутгийн бүтээн босголт нь алсдаа хөрш орнуудтайгаа зах зээлээр холбогдох зорилготой явагддаг. Үүний тулд юуны түрүүнд дотооддоо эдийн засгийн хөгжлийн суурь нөхцлийг урьдчилан бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүдэг байна.

Хятад улс гадаадын хөрөнгө оруулалтын талаар зарим нэгэн өөрчлөлт оруулж байгаа бөгөөд тухайлбал зарим хязгааралтыг үгүй болгох буюу аажмаар үе шаттайгаар өөрчлөх бодлого баримтлах тухай дурджээ. Тухайлбал санхүү, боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар зөвшөөрөх, хүүхдийн сурган хүмүүжил, настангуудыг асрах, барилгын дизайн, нягтлан бодох бизнес, худалдаа, ложистик зэрэг үйлчилгээний салбарт гадаадын хөрөнгө оруулалтын хязгааралтыг цуцалж, ердийн зориулалттай аж үйлдвэрүүдийн салбарыг нээлттэй болгох⁸ тухай заалт оржээ. Энэ бүгдээс үзэхэд хятад иргэд Монгол улсад чөлөөтэй бизнес эрхэлж болохоос гадна мөн манай

улсын иргэд ч Хятадад пүүс компаний нээж үйл ажиллагаа явуулах боломжтой болж байгаа юм.

Ийнхүү манай ойрын хөрш БНХАУ-д шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлтийн үйл явц нэгэнт эхэлж, гадаад бодлогыг нь хамарсан өөрчлөлтүүд явагдаж байгаа нь манай улстай харилцах харилцаанд ч шууд тусгалаа олж улмаар хоёр орны харилцааны хөгжилд шинэ нөхцөл байдлыг үүсгээд байна. Хоёр хөрш оронтойгоо харилцах харилцааг гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэл болгосон манай улс хоёр хөрш орных нь нэгэнд нь үүсээд байгаа энэхүү хөгжлийн шинэ нөхцөл байдлыг харгалзан үзэж улмаар өөрийн гадаад болон эдийн засгийн бодлогодоо тусгах нь зайлшгүй юм. Тэгэх тусмаа хоёр орны тэргүүнүүдийн баталсан стратегийн түншлэлийн гэрээнд талууд нөгөө талтай харилцан ашигтай харилцаа хөгжүүлэхийг өөрийн улсын гадаад бодлогын тэргүүлэх, стратегийн чиглэлүүдийн нэг болохыг онцлон тэмдэглэсэн билээ.

Юуны өмнө, Монгол-Хятадын харилцаанд нөлөө үзүүлэхүйц чухал үйл явдлууд сүүлийн 2-3 сард боллоо. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг 2013 оны 10-р сарын 22-26-нд БНХАУ-д айлчилж, "Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр" болон 10 гаруй хэлэлцээр, баримт бичигт гарын үсэг зурлаа. ХКН-ын 18 дахь удаагийн Төв Хорооны 3-р Бүгд хурал 2013 оны 11-р сарын 9-12-нд болж, БНХАУ-ын шинэтгэл, нээлттэй бодлогыг гүнзгийрүүлэх тухай чухал шийдвэр гаргалаа. Энэ хоёр үйл явдал Монгол, Хятад хоёр улсын төдийгүй олон улсын хэвлэл мэдээлэл, судлаач, улс төрч, эдийн засагч нарын анхаарлын төвд буй судалгааны чухал сэдэв болоод байна. Иймд хурлыг зохион байгуулагчид энэ хоёр үйл явдлын талаар мэргэжлийн судлаачид, дипломатууд, албаны хүмүүсийн үзэл бодол, байр суурийг Монголын олон нийтэд хүргэх нь зүйтэй хэмээн үзэж энэхүү эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн юм.

Хоёрдугаарт, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, БНХАУ-ын ЭСЯ хоёр бол Монгол-Хятадын харилцаа, хамтын ажиллагааг стратегийн түншлэлийн түвшинд харилцан

ашигтай, тал бүрээр хөгжүүлэх, хоёр ард түмний найрамдал, харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх тал дээр ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг. Өмнөд хөрш БНХАУ дахь шинэтгэл, нээлттэй бодлого цаашид хэрхэн гүнзгийрэхийг хөрш орнуудын нэгэн адил Монгол орон анхааралтай ажиглаж байна. Хятадын шинэ удирдлагын зүгээс гаргасан энэхүү шийдвэр нь 1978 оноос эхэлсэн шинэтгэл, нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх явцад олсон амжилтаа бататган, Хятадын нийгэмд тулгамдаж буй асуудал, бэрхшээл, алдаа дутагдлыг засч залруулах, мөн зах зээлийн тогтолцоо руу улам эрчимтэй орох замаар Хятадын хөгжлийн тогтвортой байдлыг хангаж, шинэтгэл, нээлттэй бодлогыг улам гүнзгийрүүлэхэд чиглэж байна. Өнөөгийн үе шатны шинэтгэлийн бодлогын онцлог бол эдийн засгийн хөгжлийн загварыг нэлээд ул суурьтай өөрчилж байгаад орших бөгөөд ач холбогдол, далайцаараа дэлхийн эдийн засагт ч шууд нөлөөлөх юм. Иймд бид хөршийнхөө эдийн засаг, улс төр, нийгмийн хүрээнд гарч буй, ойрын ирээдүйд гарах хувьсал өөрчлөлтийн талаарх мэдээлэл, ялангуяа Хятадын нэртэй эрдэмтний үзэл бодол, байр суурийг олон нийтэд хүргэхийг зорьж байна.

Гуравдугаарт, Хятадын шинэтгэл, нээлттэй бодлого амжилттай үргэлжлэн гүнзгийрэх нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд шинэ түлхэц үзүүлэх, түүний дотор уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний зах зээл өргөжин тэлэхэд таатай нөхцөл бололцоо бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, БНХАУ-д шинэтгэл, нээлттэй бодлого гүнзгийрэхийн хэрээр өмнөд хөрш улам нээлттэй, зах зээлийн тогтолцоонд шилжих үйл явц улам түргэсэх нь манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд шинэ үе шат, шинэ боломж нээгдэх болно хэмээн судлаач, шинжээчид таамаглаж байна.

Хятадын шинэтгэл, нээлттэй бодлого цаашид хэрхэн гүнзгийрэн үргэлжлэх, Хятадын шинэ удирдагчид ямар бодлого, зорилт дэвшүүлж байгаа талаар болон Монгол-Хятадын стратегийн түншлэл хэрхэн хөгжих, өнөөгийн тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар олон чухал мэдээлэл сонсож, сонирхолтой сурвалжлага хийх боломжийг энэ хурал та бүхэнд олгох болно.

Хятадын шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлтийн гол зорилго бол зах зээл рүү улам эрчимтэй ороход чиглэгдэж байгаа болно. Үүнтэй холбогдуулан ХКН-ын ТХ-ны 3-р бүгд хурлаас гарсан шийдвэрийн "Нээлттэй эдийн засгийн шинэ механизмыг байгуулах "хэсэгт дотоод гадаад зах зээлийг сайтар уялдуулах, эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох мөн түүнийг тэргүүлэх, үүний тулд дотоод гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг нэгтгэн нэг болгож гадаад хөрөнгө оруулалтын бодлогыг тогтвортой, ил тод болгох тухай заалт орсон нь мөн манай хоёр орны харилцаанд ч шууд хамааралтай зүйл хэмээн бодогдоно. Тус баримтанд мөн гадаадад хөрөнгө оруулагч аж ахуйн нэгж болон хувь хүний статусыг өндөржүүлэх, компаниудыг нэгтгэн нийлүүлэх замаар аж ахуйн нэгж байгуулах, үнэт цаас худалдан авах замаар болон бусад хөрөнгө оруулагчидтай хамтран хөрөнгө оруулахыг зөвшөөрөнө гэж заажээ⁹. Үүнээс гадна гадаад дахь хөрөнгө оруулалтын хяналтын системийг өөрчлөх, консулын зүгээс хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэргээр эрх ашгийг нь хамгаалах замаар хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны системийг боловсронгуй болгох¹⁰ тухай өгүүлжээ.

Эх газрын хилийн бүст нээлттэй бодлогыг өргөжүүлэх, тээврийн салбарт зах хязгаарын нутгуудын хооронд хамтын ажиллагааг өргөжүүлэхээс гадна хил орчмын нутгуудыг хөрш орнуудтай нь холбох эдийн засаг- зам тээврийн сүлжээг бий болгох тухай дурджээ. Энэ нь дотоод гадаад дахь шинэтгэл, нээлттэй бодлогын уялдаа холбооны нэг тод жишээ юм. Ер нь судлаач хүний нүдээр харахад Хятад улсын зах хязгаар, хил орчим нутгийн бүтээн босголт нь алсдаа хөрш орнуудтайгаа зах зээлээр холбогдох зорилготой явагддаг. Үүний тулд юуны түрүүнд дотооддоо эдийн засгийн хөгжлийн суурь нөхцлийг урьдчилан бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүдэг байна.

Хятад улс гадаадын хөрөнгө оруулалтын талаар зарим нэгэн өөрчлөлт оруулж байгаа бөгөөд тухайлбал зарим хязгааралтыг үгүй болгох буюу аажмаар үе шаттайгаар өөрчлөх бодлого баримтлах тухай дурджээ. Тухайлбал санхүү, боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар зөвшөөрөх, хүүхдийн сурган хүмүүжил, настангуудыг асрах, барилгын дизайн, нягтлан

бодох бизнес, худалдаа, ложистик зэрэг үйлчилгээний салбарт гадаадын хөрөнгө оруулалтын хязгааралтыг цуцалж, ердийн зориулалттай аж үйлдвэрүүдийн салбарыг нээлттэй болгох¹¹ тухай заалт оржээ. Энэ бүгдээс үзэхэд хятад иргэд Монгол улсад чөлөөтэй бизнес эрхэлж болохоос гадна мөн манай улсын иргэд ч Хятадад пүүс компаний нээж үйл ажиллагаа явуулах боломжтой болж байгаа юм.

Ийнхүү манай ойрын хөрш БНХАУ-д шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлтийн үйл явц нэгэнт эхэлж, гадаад бодлогыг нь хамарсан өөрчлөлтүүд явагдаж байгаа нь манай улстай харилцах харилцаанд ч шууд тусгалаа олж улмаар хоёр орны харилцааны хөгжилд шинэ нөхцөл байдлыг үүсгээд байна. Хоёр хөрш оронтойгоо харилцах харилцааг гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэл болгосон манай улс хоёр хөрш орных нь нэгэнд нь үүсээд байгаа энэхүү хөгжлийн шинэ нөхцөл байдлыг харгалзан үзэж улмаар өөрийн гадаад болон эдийн засгийн бодлогодоо тусгах нь зайлшгүй юм. Тэгэх тусмаа хоёр орны тэргүүнүүдийн баталсан стратегийн түншлэлийн гэрээнд талууд нөгөө талтай харилцан ашигтай харилцаа хөгжүүлэхийг өөрийн улсын гадаад бодлогын тэргүүлэх, стратегийн чиглэлүүдийн нэг болохыг онцлон тэмдэглэсэн билээ.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ Шинэтгэл нээлттэй бодлогын тал бүрээр гүнзгийрүүлэх нэн чухал асуудлуудын тухай ХКН-ын Төв хорооны шийдвэр

² Мөн тэнд

³ Хил хязгаарын гадаад үйл ажиллагааны талаархи зөвлөлгөөн дээр Хятадын дарга Си Зиньпиний хэлсэн үг- http://www.minwan.com/Beijing/2013-10-26_08:07:00

⁴ www.cnr.cn.zhongguo_guanbo_wan.2013.10.26

⁵ www.zhongguo_guanbo_wan.2013.10.26

⁶ Шинэтгэл нээлттэй бодлогын тал бүрээр гүнзгийрүүлэх нэн чухал асуудлуудын тухай ХКН-ын Төв хорооны шийдвэр

⁷ Мөн тэнд

⁸ Шинэтгэл нээлттэй бодлогын тал бүрээр гүнзгийрүүлэх нэн чухал асуудлуудын тухай ХКН-ын Төв хорооны шийдвэр

⁹ Шинэтгэл нээлттэй бодлогын тал бүрээр гүнзгийрүүлэх нэн чухал асуудлуудын тухай ХКН-ын Төв

хорооны шийдвэр

¹⁰ Мөн тэнд

¹¹ Шинэтгэл нээлттэй бодлогын тал бүрээр гүнзгийрүүлэх нэн чухал асуудлуудын тухай ХКН-ын Төв хорооны шийдвэр